НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 01 — Улаанбаатар хот

| № | ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Хөтөлбөрийн дүн | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр: Улс | Эх үүсвэр: Нийслэл | Эх үүсвэр: Дүүрэг | Эх үүсвэр: Гадаад зээл | Эх үүсвэр: Гадаад тусламж | Эх үүсвэр: Төр, хувийн хэвшил | Нийт төсөвт өртөг (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин 2023 | Хүрэх түвшин: Зорилтот түвшин | Хүрэх түвшин: Төсөв (сая төгрөг) | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | | | | | | | | | | |
| Салбарын үр дүн: Улаанбаатар "20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлого, төлөвлөлтийг боловсруулж, төвлөрлийг задлан шинээр байгуулагдах 14 хот, 42 нэгж хорооллыг хөгжүүлж иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | | | | | | | | |
| Зорилтын үр дүн: 1.3.Инженерийн дэд бүтцийн бодлогын баримт бичиг боловсруулж, эх үүсвэр, шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлж, төвлөрөл ихтэй хэсгийн шугам сүлжээг нэгдсэн байдлаар хонгилын системд шилжүүлэх замаар тасралтгүй найдвартай байдлыг ханган иргэдийн амьдрах орчныг сайжруулна. | | | | | | | | | | | | | | | | | | |
| 141 | 1.3.14. Ундны усны эх үүсвэрийн бүсийн дэглэмийг мөрдүүлж, Баруун эх үүсвэрийг ашиглалтад оруулна. | Ундны усны эх үүсвэрийн бүсийн дэглэмийн аюулгүй байдал хангагдана. | 2 | Ундны усны эх үүсвэрүүдийн бүсийн дэглэм, худгуудад хяналт шалгалт хийж, хууль, дүрмийн хэрэгжилтийг хангана. | 2025-2028 | - | - | - | - | - | - | - | Стандартын хэрэгжилт, хувь | - | 100 | - | Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/12 дугаартай удирдамжийн дагуу ундны усны эх үүсвэрүүд, дамжуулах станц , гүний худаг, ус түгээх байр, төвлөрсөн ус хангамжийн сүлжээний хэрэглэгчийн цэг зэрэг 219 объектоос 467 ундны усны дээж авч, Стандарт хэмжил зүйн газрын Нийслэлийн лабораторид хими, нян судлал, хүнд металлын шинжилгээг хийлгэсэн. Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнгээр, 58 дээж буюу 21.4 % нь Хүрээлэн буй орчин. Эрүүлийг хамгаалах. аюулгүй байдал.Ундны ус. эрүүл ахуйн шаардлага MNS 0900:2018 стандартын шаардлага хангахгүй гарсан. Дээрх стандартын шаардлага хангаагүй, 65 объектын шугам сүлжээ, нөөцийн савыг угаан халдваргүйжүүлж, давтан шинжилгээнд хамруулан, стандартын шаардлагад нийцүүлэн, шинжилгээний дүнг үндэслэн, улсын (ахлах) байцаагчийн 134 дүгнэлт гаргаж, холбогдох хуулийн этгээд, иргэнд хүргүүллээ. Давтан шинжилгээгээр ундны ус нь стандартын шаардлагад нийцээгүй, Шүрэнхаан уул ХХК-д Зөрчлийн тухай хуулийн дагуу 2.000.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, барагдуулан, албан даалгавраар хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, стандартын шаардлага хангуулсан байна. | 100 |
| ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | | | | | | | | | | | | |
| Салбарын үр дүн: Хотын төлөвлөлт, хүн амын өсөлттэй уялдуулан нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | | | | | | | | |
| Зорилтын үр дүн: 2.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж болон спортын барилга байгууламжийн | | | | | | | | | | | | | | | | | | |
| 241 | | | 1 | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын суралцагчдын насны онцлогт тохирсон эрүүл мэндийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна. | 2025-2028 | - | 200 0 | - | - | - | - | 200 0 | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ | - | 200 | 50 0 | Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн "Амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай" А/133 дугаар захирамж, НЭМГ-ын даргын 03 дугаар сарын 10-ны өдрийн удирдамжаар "Маскаа зүүцгээе" аян өрнүүлэн ажиллаж байна.<br>Аяны хүрээнд нийслэлийн харьяа Эрүүл мэндийн байгууллага, өрхийн Эрүүл мэндийн төвүүд цэцэрлэгт амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх, орчны эрүүл ахуйг хангах, хувийн ариун цэврийг сахих, олон нийтийн газарт амны хаалт зүүх ба түүний ач холбогдлын талаар нийт 219 удаагийн сургалтыг цэцэрлэгийн орчинд зохион байгуулж нийт 14,339 хүүхдийг хамруулсан. Уг аянтай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгслээр амьсгалын замаар дамжих халдвараас сэргийлэх агуулга бүхий 370 гаруй зөвлөмж бүхий зурагт хуудас, видео боловсруулж, давхардсан тоогоор 1,310,000 гаруй хүнд хүргэсэн. | 100 |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | | | | Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, сурагчдын нас хүйсийн онцлогт тохируулан нийт 7006 удаагийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, 154,773 хүүхдийг хамруулж ажиллаа. Үүнд:<br>1. 2025 оны 4 сард "Өсвөр үеийнхнийг сонсоё, ойлгоё" аяныг өрнүүлж, 9 дүүргийн ЭМТ, 2 нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс харьяалах нутаг дэвсгэр дэх цагдаагийн газар, Засаг даргын Тамгын газартай хамтран ерөнхий боловсролын сургуулиуд дээр "Хорт бодис, дэлгэцийн хэрэглээ, вейп ба тамхи, донтолт, эрүүл зохистой хооллолт /таргалалт, шим тэжээлийн хомсдол/, хөдөлгөөний дутагдал, нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн эрүүл ахуй, аюултай бэлгийн харилцаа, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нь, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвүүдээр нийт 108 ерөнхий боловсролын сургуулийн 10-18 насны 41,193 сурагчдад 972 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгсөн. | |
| 242 | 2.1.1. Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, өсвөр насныхан нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ. | Эрүүл мэндийн боловсролыг үе шаттай олгож, эрүүл дадал хэвшилтэй иргэнийг төлөвшүүлнэ. | 2 | Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын насны онцлогт тохирсон эрүүл мэндийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна. | 2025-2028 | - | 460 0 | - | - | - | - | 460 0 | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ | 860 | 7000 | 100 | 2. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид суралцаж буй 40,753 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт оруулахаас 2025 онд 33,310 хүүхдийг хамруулж, хамтран ажиллаж буй 86 эмнэлгийн эмчлэгч эмч нар урьдчилан сэргийлэх үзлэг болон эмчилгээнд хүүхдээ авчирсан эцэг, эх, асран хамгаалагч нарт шүд угаах арга техник, шүдээ арчлах, шүдэнд ээлтэй хоол хүнс сэдвээр 5,418 удаагийн сургалтыг хийсэн.<br>3.АШУҮИС-ийн НАСС-ийн хүүхдийн тэнхимтэй хамтарч, тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт амны хөндийн арчилгаа сэдвээр 70 удаагийн ганцаарчилсан сургалтад хүүхдийг эцэг, эхийн хамт хамруулсан.<br>4."Электрон тамхины хор хөнөөл" сэдэвт сургалтыг 44 ЕБС-ийн ахлах болон дунд ангийн 10,638 сурагчдыг хамруулан зохион байгуулсан.<br>5."Угаарын хийн хордлогоос сэргийлье" сэдэвт 12 удаагийн сургалтыг нийт 4.283 цэцэрлэгийн багш, сурагчдад зохион байгуулсан.<br>6. 8 дүүргийн эрүүл мэндийн төв, 1 нэгдсэн эмнэлэг дэх өсвөрийн кабинетуудаас бэлгийн болон нөхөн үржихүйн эрхтний эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах, стресс даван туулах тухай, зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, мансууруулах бодис, электрон утаат тамхины хор уршиг, донтолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 490 удаагийн сургалт зохион байгуулж, 24600 хүүхдийг хамруулсан. | 100 |
| | | | | | | | | | | | | | Үе тэнгийн зөвлөгч, тоо | 305 | 2500 | | Эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан сурагчдын дунд 2025 онд 2500 үе тэнгийн зөвлөгч бэлтгэсэн. Тухайлбал:<br>"Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё" сэдэвт сарын аяныг анхан шатны 126, лавлагаа шатлалын 12 эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан 2025 оны 04 сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Тус аяны хүрээнд болон дүүргийн эрүүл мэндийн төвүүдээс бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замын халдвар өвчнөөс сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах сэдвээр 2246 үе тэнгийн зөвлөгч бэлтгэсэн.<br>Мөн Нийслэлийн 4 дүүрэгт " Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн" -ийг 9-12 насны сурагчдын дунд зохион байгуулж 254 үе тэнгийн сургагч багшийг бэлтгэн 1.077 хүнд "Амны хөндийн эрүүл, зөв дадал" сэдвээр сургалт зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 245 | төвүүдийг үе шаттайгаар байгуулж, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар амьдралын зөв дадал, хэвшлийг бий болгож, урьдчилсан сэргийлэх эрт илрүүлгийн хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлж, зохилон тохиолдох халдварт бус өвчлөлийг бууруулна. | Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, амьдралын чанарыг сайжруулна. | 2 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийг 10 хувиар нэмэгдүүлж, халдварт бус өвчний тохиолдлыг бууруулна. | 2025-2028 | - | - | - | - | - | - | - | Эрт илрүүлэгт хамрагдалтын хувь | 40 | 45 | - | Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 4 нэгдсэн эмнэлэг, 4 тосгоны эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд зохион байгуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн яамны харьяа эмнэлгүүдээс Улсын гуравдугаар төв эмнэлэг оролцож байна.<br>Нийслэлийн хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын байдлаар эрт илрүүлэгт 911892 хүн буюу 59.5%-ийг хамруулсан. 2025 онд 37692 иргэн хамрагдсан байна. Эрүүл мэндийн сайдаас ирүүлсэн албан бичгийн дагуу эрт илрүүлгийг зогсоосон болно. | 100 |
| | | | | | | | | | | | | | Хяналтад авсан өвчтөн, тоо | 125441 | 130000 | - | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдээс эмчилгээ хяналт шаардлагатай 132,457 хүнийг хяналтад авч ажилласан. | 100 |
| | | | | | | | | | | | | | Эрүүлжилтийн хувь | 15 | 18 | - | Нийслэлийн хэмжээнд хамрагдсан хүн амын дунд хоол боловсруулах замын эмгэг хамгийн түгээмэл тохиолдож, зүрх судасны өвчин, бодисын солилцооны хам шинж зэрэг өвчнүүд удаалж байна. Нийт үзлэгт хамрагдсан иргэдийн 21%-г хяналтад авч эмчилгээнд хамруулж байна. | 100 |
| 246 | | | 3 | Нийгмийн эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар дүүрэг бүрт байгуулна. | | 12,500 0 | - | - | - | - | - | 12,500 0 | Шинээр байгуулсан Нийгмийн эрүүл мэндийн төв, тоо | 2 | 2 | - | Багануур, Баянзүрх дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулагдан ажиллаж байна.<br>Чингэлтэй дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв буюу эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилгыг тус дүүргийн 14 дүгээр хороонд шинээр барьж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90%-тай байна. 2026 оны I улиралд ашиглалтад орно.<br>Дүүргийн эрүүл мэндийн төвийг нийгмийн эрүүл мэндийн төв, дүүргийн нэгдсэн эмнэлэг болгон өөрчилж нийгмийн эрүүл мэндийн төвүүдийг шинээр байгуулахаар төлөвлөгдсөн. Дүүргүүдийн барилга байгууламж, хүний нөөцийн судалгаа болон дүүргүүдэд одоо ашиглаж буй барилга байгууламжийг ашиглах судалгааг гарган Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. Эрүүл мэндийн яамнаас "Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах" тушаал, бүтцийн болон ажиллах журам, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй хүлээлтийн байдалтай байна. | 90 |
| 247 | | | 4 | Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчид, зорилтот бүлгийн 6 настай хүүхдүүдийн эрт илрүүлгийг зохион байгуулж, эрүүлжүүлнэ. | 2025-2028 | 23,000 0 | | | | | | 23,000 0 | Үзлэгт хамрагдсан хүүхдийн түвшин, хувь | - | 78 | 5,750 0 | Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын 2024 оны хамтарсан А/413, А/151 дүгээр тушаалын дагуу Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдын нүд, шүд, зүрхний эмгэгийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг хийх арга хэмжээг зохион байгуулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид суралцаж буй 40752 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт оруулахаас 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 36,553 хүүхэд буюу 89.7%-г хамруулсан. Үзлэг дууссан бөгөөд ЭМЯ-ны шийдвэрийн дагуу 2025 оны 9 сараас үзлэг эхлэх байсан ч дэмжигдээгүй тул зогссон. | 100 |
| | | | | | 2025-2028 | | | | | | | | Эмчилгээнд хамрагдаж эрүүлжсэн хүүхдийн түвшин, хувь | - | 50 | | Үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар 15,724 хүүхдийг буюу 43.02 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. | 86 |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 248 | 2.1.3. Халдварт өвчнөөс сэргийлэх, **илрүүлэх, хянах, эмчлэх** үйл ажиллагааг сайжруулж, эмчилгээний хамрагдалтыг 98 хувьд хүргэж, товлолт дархлаажуул | Халдварт өвчний илрүүлэг, тандалтыг сайжруулж, **эмчилгээний** | 1 | Товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг 98 хувьд хүргэнэ. | 2025-2028 | 200 0 | - | - | - | - | - | 200 0 | Дархлаажуулалтад хамралтын түвшин, хувь | 96 | 96 | 50 0 | Товлолт дархлаажуулалтын хамралтын мэдээг сар бүр тогтмол гарган ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд хүргүүлж байна. 2025 оны эхний 10 сарын байдлаар Товлолт вакцины 17 тунгийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 394,849 хүүхэд хамрагдахаас 384,794 хүүхэд хамрагдаж хамралтын дундаж 97.5% байна. Үүнд:<br>1.БЦЖ (1 тун) – 99.5%<br>2.Гепатит В (1 тун) – 99.3%<br>3.Саа (4 тун) – 95,0%<br>4.Тавт (3 тун) – 95.5%<br>5.УГУ (2 тун) – 97,3%<br>6.Гепатит А (2 тун) – 95.3%<br>7.Пневмококк (3 тун) – 95.5%<br>8.Сахуу-татран (2 тун) – 73,3% байна.<br>2025 оны эхний 10 сарын байдлаар Хүний папиллома вирус (1тун) дархлаажуулалтын хамрагдалт - 47.8%-д хүрсэн.<br>Хүний папиллома вирусын эсрэг вакцины "Дархлаажуулалтын үндэсний товлол"-д шинээр нэвтрүүлсэнтэй холбогдуулан дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал: Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1256 дугаар захирамж, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын "Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтыг нийслэлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай" А/168 дугаар тушаал, "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" А/179 дүгээр тушаалуудыг гарган хэрэгжилтийг хангасан.<br>НЭМГ-ын даргын 2025 оны А/29 дүгээр тушаалаар нийслэлийн ЕБС-иудын дунд "Эрүүл чийрэг өсвөр үе" аян, нийслэлийн анхан шатны<br>эрүүл мэндийн байгууллагуудын дунд "Зорилтот насны хүүхдийн нөхөн дархлаажуулалтыг эрчимжүүлэх аян"-ыг тус тус зохион байгуулсан. Аяны хүрээнд 6 сургууль, 4 ӨЭМТ шалгарч, 3,084 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан байна.<br>Мөн НЭМГ-ын даргын 2025 оны "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх тухай" А/321 дүгээр тушаалын дагуу НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран Нийслэлийн төрийн, хувийн өмчийн сургуулиудын 325 эмч, мэргэжилтэнг сургалтад хамруулан чадавхжуулсан. | 100 |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 249 | алтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулна | амжилтын нэмэгдүүлнэ. | 2 | Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулж, өвчлөлийг бууруулна. | | 500 0 | - | - | - | - | - | 500 0 | Эмчилгээний амжилтын түвшин, хувь | 76 | 78.9 | 100 0 | Нийслэлийн хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын байдлаар шинээр илэрсэн сүрьеэгийн 1022 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 6.2 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56 тохиолдлоор буюу 0.5 промилиор буурсан байна. Нийт тохиолдлын 8.5%-ийг 0-14 насны хүүхэд эзэлж байна.<br>Нийслэлийн харьяа дүүргийн сүрьеэгийн диспансер, кабинет болон идэвхитэй илрүүлгээр нийт 79,946 үзлэг хийснээс 47,968 буюу 60.2% нь урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн. Үүнээс зорилтот бүлгийн 4800 гаруй хүнээс сүрьеэ өвчний илрүүлэлтийн хувь 21,3% байна.<br>Сүрьеэ, өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулах зорилгоор:<br>- Эрсдэлт бүлгийн идэвхитэй илрүүлэлтийг зохион байгуулж, 2025 оны 03 дугаар сард Багануур дүүрэгт 150 иргэнийг хамруулснаас 1 хуучин өвчилж байсан ба сүрьеэгийн сэжигтэй 7 хүнээс цэрний шинжилгээ авсан,<br>- 2025 оны 5 дугаар сард СХНЭ, СХД-ийн 26-р хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч нартай хамтран зохион байгуулж Улаанчулуутын хогийн цэгт ажиллаж, хог түүдэг 43 иргэнийг хамруулснаас 10 хүн хуучин сүрьеэгээр өвчилж байсан ба сүрьеэгийн сэжигтэй 3 хүнээс цэрний шинжилгээ авсан.<br>- 2025 оны 3 сарын 27-ны өдөр НЗДТГ-ын 112 албан хаагчийг эрт илрүүлэгт хамруулснаас 2 нь хуучин өвдөөд эдгэрсэн байсан ба сүрьеэгийн сэжигтэй 5 хүнээс цэрний шинжилгээ тус тус авсан бөгөөд шинэ сүрьеэгийн тохиолдол илрээгүй.<br>НЭМГ-ын даргын баталсан "Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийг тэмдэглэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу эмч, эрүүл мэндийн ажилтан болон иргэд, төрийн бус байгууллагуудад чиглэсэн 13 төрлийн<br><br>үйл ажиллагааг зохион байгуулсан.<br>Нийт тохиолдлын 99%-ийг эмчилгээнд хамруулж, эмчилгээний амжилт 79.9% байна. | 100 |
| 250 | | | 1 | Ургийн гажгийг илрүүлэх хэт авиан тоног төхөөрөмжийн хяналтыг нэмэгдүүлнэ. | 2025-2028 | 1,000 0 | 1,000 0 | - | - | - | - | 2,00 0 | Ургийн гажиг илрүүлэг тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллага, тоо | 8 | 2 | 500 0 | Баянгол, Сонгинохайрхан, Багануур, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Сонгинохайрхан, Сүхбаатар нэгдсэн эмнэлэг, Хүрээ амаржих газар буюу нийт 8 эрүүл мэндийн байгууллага ургийн гажгийг илрүүлэх 4D хэт авианы тоног төхөөрөмжөөр хангагдсан. 2025 оны 10 сарын байдлаар 4189 жирэмсэн эмэгтэйд ургийн бүтцийн гажгийн илрүүлэг, оношилгоо хийж 12 ургийн гажиг илрүүлсэн.<br>Ургийн хромосомын гажиг илрүүлэх жирэмсний эхний 3 сарын нийлмэл илрүүлэг шинжилгээг хийх бэлтгэл ажлыг хангах чиглэлийг харьяа эрүүл мэндийн байгууллагад 2025 оны 05 сарын 06-ны өдрийн 01/1085 дугаар бичгээр хүргүүлэн арга зүйгээр ханган ажиллаж байна. Жирэмсний эхний 3 сарын хэт авиан шинжилгээ хийх чадамжтай (Fetal Medicine Foundation-ий албан ёсны сертификаттай, програмын эрх эзэмшсэн) эмч нийслэлийн 3 амаржих газарт 9, дүүргийн эрүүл мэндийн төвд 7 эмч бэлтгэгдсэн. Хоёрол тестийн шинжилгээг Нийслэлийн Өргөө амаржих газар хийж эхэлсэн. | 70 |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 251 | 2.1.4. Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна. | Ургийн гажгийг эрт үед нь илрүүлж, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 1000 амьд төрөлтөд 2 промилээр бууруулна. | 2 | Нярайн скрининг шинжилгээг үе шаттай нэмэгдүүлнэ. | 2025-2028 | 700 0 | 700 0 | - | - | - | - | 1,400 0 | Скрининг шинжилгээнд хамрагдсан нярайн түвшин, хувь | 25 | 30 | 350 0 | Нийслэлийн хэмжээнд нярайн тусламж, үйлчилгээ үзүүлдэг Өргөө , Хүрээ, Амгалан амаржих газар, Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн төв нь 2025 оны эхний 10 сарын байдлаар нийт 12513 амьд нярай төрж нярайн скринингд хамруулахаас түнхний хэт авиан шинжилгээ 12346 буюу 98.6%, нүдний угийн улаан рефлекс илрүүлэгт 9631 буюу 77%, сонсголын скрининг 5067 буюу 40.5%, пульсоксиметрийн скрининг 7710 буюу 61.6%, зулайн хэт авиан шинжилгээнд дутуу нярайг 100%, гүйцэт нярайг 6315 буюу 50.5% тус тус хамруулж, нярайн скрининг хамралтын дундаж түвшин 65.6% тай байна. Тухайлбал:<br>-Налайх дүүргийн эрүүл мэндийн төв 214 нярай төрснөөс түнхний хэт авиан шинжилгээ, нүдний угийн улаан рефлексийн илрүүлэгт 213 нярайг 99.5%,<br>-Багануур дүүргийн эрүүл мэндийн төв 381 нярай төрснөөс сонсгол, нүдний угийн улаан рефлексийн илрүүлэг, түнхний хэт авиан шинжилгээнд 373 нярайг 98%,<br>-Нийслэлийн Хүрээ амаржих газар 2786 нярай төрснөөс нүдний угийн улаан рефлексийн илрүүлэг-2779 / 99.7%/, зүрхний хэт авиан шинжилгээ-2779 / 99.7%/, түнхний хэт авиан шинжилгээнд 2779 / 99.7%/, зулайн хэт авиа шинжилгээ-123 / 4.4%/,<br>-Нийслэлийн Амгалан амаржих газар 4662 нярай төрснөөс нүдний угийн улаан рефлексийн илрүүлэг – 4093 / 87.8%/, пульсоксиметр - 3240/70%/, түнхний хэт авиан шинжилгээ – 4511 / 96.7%/ , сонсгол – 3901/83.6%/, зулайн хэт авиан шинжилгээ – 401/8.6%/,<br>-Нийслэлийн Өргөө амаржих газар 4470 нярай төрснөөс нүдний угийн улаан рефлексийн илрүүлэг- 2173 /48.6%/, пульсоксиметрээр хүчилтөрөгчийн ханалт тодорхойлох -4470/100%/, түнхний хэт авиан<br>шинжилгээ-4470/100%/, зулайн хэт авиан шинжилгээнийг 3135/ 70.1%/, сонсголын скрининг -793 /18%/нярайг тус тус хамруулсан байна. | 100 |
| 252 | | | 3 | Тав хүртэлх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр тусламж үйлчилгээг чанаржуулна. | | - | 100 0 | - | - | - | - | 100 0 | 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 15.7 | 14.9 | 20 0 | Нийслэлийн хүрээ амаржих газар сонсгол , пульсооксиметрийн скрининг, Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн төв зулайн хэт авиан скрининг хийхэд тоног төхөөрөмж хангалт байхгүй тул одоогоор хийгдээгүй байна. | 0 |
| 253 | | | 4 | Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийн хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ. | 2025-2028 | - | 160 0 | - | - | - | - | 160 0 | Жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд хамрагдсан эмэгтэйчүүдийн түвшин, хувь | 62 | 65 | 40 0 | Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэлд хамрагдсан эмэгтэйчүүд 41,987 буюу 64.7%-тай байна. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/11 дүгээр тушаалын дагуу Нийслэлийн харьяа 9 дүүргийн эрүүл мэндийн төвд дүүргийн хэмжээнд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг сайжруулах чиглэл өгч шинэчлэн, нийт нөхөн үржихүйн насны **422,442** эмэгтэйчүүд байгаагаас **62,268** зорилтот бүлгийн эмэгтэйчүүд байна. 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлээр **41,987** зорилтот бүлгийн эмэгтэй буюу 67,4% хамрагдсан байна. | 100 |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 254 | | Эхийн сэргийлж болох эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг бууруулна. | 5 | Өндөр эрсдэлтэй зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлт, үр хөндөлт, жирэмслэлтээс сэргийлэх нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулна. | 2025-2028 | 100 0 | 60 0 | - | - | - | - | 160 0 | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 1 | 2 | 40 0 | Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг хэрэглэхийн ач холбогдол, гэр бүл төлөвлөлтийн аргуудыг таниулах, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх тухай" А/770 дугаар захирамжийг боловсруулан батлуулж ажиллалаа.<br>1.Захирамжийн дагуу жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг таниулах хөтөч дэвтрийг боловсруулан 28000 ширхэгийг гарган 9 дүүргийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг хэрэглэхийн ач холбогдол, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх тухай мэдээлэл, сургалтыг үйл ажиллагаанд ашиглаж байна.<br>2.Оюутны бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх зорилгоор сургалт зохион байгуулахад хамтран ажиллах тухай албан бичгийг Боловсролын Ерөнхий газарт хүргүүлсэн. 11 сарын байдлаар МУБИС, МУИС, ДХИС, ХААИС, ШУТИС, ҮТИС, Оточ манрамба, МҮИС, ИЗИС, ТЗИС, ҮБХИС, УБЭДС, БТДС, ТТДС, зэрэг 14 их, дээд сургуулийн 14,080 оюутанд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, мэдлэг хандлагыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.<br>Мөн Налайх, Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн Тамгын газруудтай хамтарч, 12 удаагийн сургалтад хороодын хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан гэзд нийт 1,369 албан хаагчдыг хамруулсан. | 100 |
| 255 | 2.1.5. Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж, тусламж үйлчилгээний хүртээмж, нэр төрлийг нэмэгдүүлнэ. | Иргэдэд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ойртуулна. | 1 | Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлнэ. | 2025-2028 | - | - | - | - | - | - | - | Бодлогын баримт бичигт санал өгч, төлөвлөлт хийх ажлын хэрэгжилт, хувь | - | 100 | - | Баримт бичиг боловсруулах ажлын явц 80-тай байна.<br>Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу "20 минутын хот" концепцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий НЭМГ-ын Ажлын хэсгийн гишүүдийг 2024 оны А/142 дугаар тушаалаар байгуулсан.<br>Ажлын хэсгийн гишүүд Нийслэлийн харьяа 28 байгууллагыг 14 хотын газрын зураг дээр байрлуулж, холбогдох саналыг НЗДТГ-т хүргүүлсэн.<br>Тус онд "20 минутын хот" концепцийн Ажлын хэсгийн гишүүд ЭМЯ-ны Ажлын хэсэгтэй хамтарсан нийт 4 удаагийн уулзалт хурлыг зохион байгуулсан.<br>Нийслэлийн эрүүл мэндийн салбарыг бүсчилсэн хөгжлөөр хөгжүүлэх зураглал, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах шатандаа явж байна."20 минутын хот" концепцийг хэрэгжүүлэх асуудлаар 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хурлын Г.Лувсанжамц гишүүнтэй уулзалт, хэлэлцүүлэг хийсэн. Уулзалт хэлэлцүүлгээр Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авах бүтэц, зохион байгуулалтын талаар НЭМГ-ын ажилчид, харьяа 28 эрүүл мэндийн байгууллагын удирдлагатай өнөөгийн нөхцөл байдал, цаашдын төлөвлөгөөний талаар хэлэлцсэн.<br>Улсын Их хурлаас "20 минутын хот" хорооллын хилийн цэсийн зааг тодорхой болоогүй, нэг жилээр хойшлуулсан тул хүлээгдлийн байдалтай байна. | 80 |
| | | | | | 2025-2028 | - | - | - | - | - | - | - | Тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллага, тоо | 149 | 151 | - | 2025 оны эхний 10 сарын байдлаар тус газрын харьяа 151 өрхийн эрүүл мэндийн төв, 29 салбар, 4 тосгоны эрүүл мэндийн төв иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.<br>Нийслэлийн 151 өрхийн эрүүл мэндийн төвийг 14 хотын газрын зураг дээр байршуулсан.<br>Мөн нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангуудыг орон зайн байршлын газрын зурагт байршуулах ажлыг зохион байгуулж байна. | 100 |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж, тусламж үйлчилгээний хүртээмж, нэр төрлийг нэмэгдүүлнэ. | мэндийн тусламж, үйлчилгээг ойртуулна. | | | 2025-2028 | - | - | - | - | - | - | - | Тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллага, тоо | 149 | 151 | - | 2025 оны эхний 10 сарын байдлаар тус газрын харьяа 151 өрхийн эрүүл мэндийн төв, 29 салбар, 4 тосгоны эрүүл мэндийн төв иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.<br>Нийслэлийн 151 өрхийн эрүүл мэндийн төвийг 14 хотын газрын зураг дээр байршуулсан.<br>Мөн нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн | 100 |
| 256 | | | 2 | Нийслэлийн өмчит эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлт хийж, үйл ажиллагааны менежментийг сайжруулна. | 2025-2028 | - | - | - | - | - | - | - | Менежмент нэвтрүүлэх ажлын явц, хувь | | 30 | - | Нийслэлийн харьяа 28 эрүүл мэндийн байгууллага, 151 өрхийн эрүүл мэндийн төвийг 14 хотын газрын зураг дээр байрлуулж, холбогдох саналыг 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ-т хүргүүлсэн.<br>"20 минутын хот" концепцийн хүрээнд нийслэлийг 14 хот, 42 хороолол болгох хил хязгаар эцэслэгдээгүй байна. 42 хорооллын хил хязгаар эцэслэсний дараагаар тухайн газар нутгийн хүн амын тоо, эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлаас хамааран анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг нэгтгэх бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх тул уг ажлын бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. | /-/ |
| 257 | 2.1.6. Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Эмч, эмнэлгийн мэргэжилтний тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ. | 1 | Нийслэлийн эрүүл мэндийн байгууллага, ажилчдын ажлын гүйцэтгэлийг үр дүнгээр тооцон үнэлж, урамшуулал олгох ажилд дэмжлэг үзүүлнэ. | 2025-2028 | - | 1,600 0 | - | - | - | - | 1,600 0 | Эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, тоо | 15, 186 | 15, 187 | 400 0 | Нийслэлийн харьяа шилдэг эрүүл мэндийн байгууллага, шилдэг эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанг ажлын гүйцэтгэл үр дүнгээр тооцон үнэлж, урамшуулал олгохоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Мөнгөн урамшуулал олгох" А/1600 дугаар захирамжийг гарган 399,715,000 төгрөгийг батлуулсан. Тус захирамжийн хүрээнд шалгуур үзүүлэлтийн дагуу нийслэлийн харьяа 28 эрүүл мэндийн байгууллагаас 2-р шатны сонгон шалгаруулалтаас шалгарсан 186 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, 15 эрүүл мэндийн байгууллагыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн урамшууллыг олгосон. | 100 |
| | **Нэгдсэн дүн (хувь)** | | | | | | | | | | | | | | | | | **90.8** |

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, НЭГДСЭН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА У.БАТ-ОЧИР

ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ХЯН ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.ЭНХТҮВШИН

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, НЭГДСЭН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН М.ХОРОЛСҮРЭН

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**
**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН**

2025 оны 12 дугаар сарын 01 | Улаанбаатар хот

| № | Хүрэх үр дүн | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин 2023 он | Зорилтот түвшин 2025 он | Шалгуур үзүүлэлтийн тайлбар | Мэдээлэл цуглуулах давтамж | Зорилтот түвшинд хүрсэн эсэх (тоон утга) | Дүн (хувь) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| | **Эрүүл мэнд, Биеийн тамир** | | | | | | | | |
| 105 | 2.1.1.Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, өсвөр насныхны нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ. | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо | тоо | 860 | 7000 | Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, зохион байгуулсан арга хэмжээ | Жилд 1 удаа | 7006 | 100 |
| 106 | 2.1.2.Нийгмийн эрүүл мэндийн төвүүдийг үе шаттайгаар байгуулж, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар амьдралын зөв дадал, хэвшлийг бий болгож, урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлж, зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийг бууруулна. | Эрт илрүүлгийн хамрагдалт | хувь | 40 | 45 | 2 жил тутамд нэг удаа хамрагдсан иргэдийн эзлэх хувь | Жилд 1 удаа | 59.50% | 100 |
| 107 | | Шинээр зохион байгуулах нийгмийн эрүүл мэндийн төв | тоо | 2 | 2 | 2025 онд нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах бэлтгэл ажлыг хангана. | Жилд 1 удаа | 1 | 70 |
| 108 | 2.1.3.Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулж, эмчилгээний хамрагдалтыг 98 хувьд хүргэж, товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулна. | Товлолт дархлаажуулалтын хамрагдалт | хувь | 96 | 96 | Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулж, эмчилгээнийй хамрагдалтыг 98 хувьд хүргэж, товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулах үйл ажиллагаа. | Жилд 1 удаа | 97.50% | 100 |
| 109 | | Эмчилгээний амжилт | хувь | 76 | 79 | | Жилд 1 удаа | 79.90% | 100 |
| 110 | 2.1.4.Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна. | 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | промиль | 15.7 | 14.9 | Тайлангийн жилд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн тоог 1000 амьд төрөлтөд харьцуулж тооцож гаргана. | Жилд 1 удаа | 17.1 | 0 |
| 111 | | 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл | промиль | 37.9 | 22 | Тайлангийн жилд бүртгэгдсэн эхийн эндэгдлийн тоог 100,000 амьд төрөлтөд харьцуулж тооцож гаргана. | Жилд 1 удаа | 40.4 | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 112 | 2.1.5.Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж, тусламж үйлчилгээний хүртээмж, нэр төрлийг нэмэгдүүлнэ. | Тусламж, үйлчилгээ үзүүлж буй анхан шатны эрүүл мэндийн байгууллага | тоо | 149 | 151 | Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж, нутаг дэвсгэрийн эдэлбэр газар, хүн амын тоог стандартад нийцүүлж, ӨЭМТ-ийг зохион байгуулах ажил. | - | 151 | 100 |
| 113 | 2.1.6.Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Эмчилгийн мэргэжилтний нийгмийн баталгаа, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байгууллага, ажилтан | тоо | 15, 186 | 15, 187 | Нийслэлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэн, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр шилдэг эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг сонгон шалгаруулж урамшуулал олгоно. | Жилд 1 удаа | 15, 187 | 100 |
| **Нэгдсэн дүн (хувь)** | | | | | | | | | **74.4** |

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, НЭГДСЭН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА У.БАТ-ОЧИР

ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.ЭНХТҮВШИН

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, НЭГДСЭН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН М.ХОРОЛСҮРЭН